

# ХААН СОЁМБО АУДИТ ХХК



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл нуур, Эгийн голын сав газрын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/16/НА-СТА-ТЗШ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Хөвсгөл аймаг  
2022 он

Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Аудитор: Г.Ичинхорлоо  
Утас: 88012671 Цахим хаяг: [ichko.0808@gmail.com](mailto:ichko.0808@gmail.com)

Хаан соёмбо аудит ХХК-ийн захирал: Х.Диймаа  
Утас: 99065668 Цахим хаяг: [info@khaansoyomboaudit.mn](mailto:info@khaansoyomboaudit.mn)

Хаан соёмбо аудит ХХК-ийн аудитор: Н.Бадамханд  
Утас: 99042699 Цахим хаяг: [info@khaansoyomboaudit.mn](mailto:info@khaansoyomboaudit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
3. Аудитын тайлан .....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	8
3.2 Байгууллагын гадаад дотоод орчин .....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	9
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	9
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	10
4.1 Ерөнхий зүйл .....	10
4.2 Материаллаг байдал .....	11
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	11
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	11
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	11
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	12
5. Аудитын илрүүлэлт .....	12
5.2 Төлбөрийн акт .....	12
5.3 Албан шаардлага .....	12
5.4 Зөвлөмж .....	12
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	12

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2022.08.20 № 01/85  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ НУУР, ЭГИЙН ГОЛЫН САВ  
ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Д.ЭРДЭНЭБОЛД ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл нуур, Эгийн голын сав газрын захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл нуур, Эгийн голын сав газрын захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас 41.1 сая төгрөгийн автомашиныг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

### Аудитын гол асуудал

Хөвсгөл нуур Эгийн голын сав газрын захиргааны төсвийн 83 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал эзэлж байна.

### Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 48 арга хэмжээ 89.2 хувийн үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу


илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЗБААТАР



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,849,991.00</b>	<b>5,299,800.00</b>
33	<b>АВЛАГА</b>	<b>550,191.00</b>	<b>00.00</b>
335	<b>Бусад авлага</b>	<b>550,191.00</b>	<b>00.00</b>
3351	Байгууллагаас авах авлага	550,191.00	00.00
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>5,299,800.00</b>	<b>5,299,800.00</b>
354	<b>Хангамжийн материал</b>	<b>5,299,800.00</b>	<b>5,299,800.00</b>
35430	Сэлбэг хэрэгсэл	100,000.00	100,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,000,000.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	4,199,800.00	5,199,800.00
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>941,008,171.73</b>	<b>941,999,298.91</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>941,008,171.73</b>	<b>941,999,298.91</b>
392	<b>Биет хөрөнгө</b>	<b>941,008,171.73</b>	<b>941,999,298.91</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	967,653,186.00	967,653,186.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-49,995,414.61	-69,348,478.33
39203	Авто-тээврийн хэрэгсэл	6,959,500.00	48,059,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-2,891,899.92	-12,062,966.55
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	29,015,744.56	29,015,744.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	-11,892,229.47	-22,591,744.68
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,437,948.84	7,437,948.84
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,828,663.58	-6,513,890.80
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,000,000.00	1,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.09	-650,000.13
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>946,858,162.73</b>	<b>947,299,098.91</b>
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>946,858,162.73</b>	<b>947,299,098.91</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>946,858,162.73</b>	<b>947,299,098.91</b>
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>946,858,162.73</b>	<b>947,299,098.91</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	946,858,162.73	946,858,162.73
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	440,936.18
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>946,858,162.73</b>	<b>947,299,098.91</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>189,823,900.00</b>	<b>198,495,800.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>41,100,000.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>00.00</b>	<b>41,100,000.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	41,100,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	41,100,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>189,823,900.00</b>	<b>157,395,800.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>185,079,400.00</b>	<b>142,728,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	185,079,400.00	142,728,800.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>4,744,500.00</b>	<b>14,667,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	14,667,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,744,500.00	00.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>218,604,105.96</b>	<b>198,054,863.82</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>218,604,105.96</b>	<b>198,054,863.82</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>180,515,557.25</b>	<b>196,988,528.68</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>94,022,249.64</b>	<b>103,801,911.00</b>
210101	Үндсэн цалин	71,418,245.50	81,725,626.00
210102	Нэмэгдэл	15,387,001.00	11,502,101.00

210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,217,003.14	8,680,700.00
210104	Урамшуулал	00.00	1,893,484.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>12,807,508.87</b>	<b>13,705,068.81</b>
210201	Тэтгэврийн даатгал	8,950,099.90	9,501,728.65
210202	Тэтгэмжийн даатгал	988,288.72	1,117,527.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	760,570.90	748,020.49
210204	Ажилгүйдлийн даатгал	189,224.71	278,850.58
210205	Эрүүл мэндийн даатгал	1,919,324.64	2,058,941.58
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>15,867,699.80</b>	<b>17,771,053.98</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,462,645.03	1,591,920.09
210302	Түлш, халаалт	13,121,756.97	13,381,393.89
210303	Цэвэр, бохир ус	1,283,297.80	2,797,740.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>7,741,699.50</b>	<b>13,380,247.00</b>
210401	Бичиг хэрэг	1,443,997.00	1,233,550.00
210402	Тээвэр, шатахуун	4,419,800.00	9,584,365.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,145,902.50	950,510.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	682,000.00	1,611,822.00
210408	Бараа материал акталсны зардал	50,000.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>7,200.00</b>	<b>00.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,200.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>808,200.00</b>	<b>855,000.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	178,200.00	855,000.00
210604	Урсгал засвар	630,000.00	00.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,980,600.00</b>	<b>3,148,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,980,600.00	3,148,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>11,645,793.48</b>	<b>2,118,510.07</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,940,993.48	1,613,810.07
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	69,300.00	71,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	51,500.00	95,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	34,000.00	41,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	297,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>33,634,605.96</b>	<b>42,208,737.82</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,959,800.00	2,099,865.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	30,674,805.96	40,108,872.82
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>38,088,548.71</b>	<b>1,066,335.14</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>27,617,400.00</b>	<b>00.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	27,617,400.00	00.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>10,471,148.71</b>	<b>1,066,335.14</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,471,148.71	1,066,335.14
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-28,780,205.96</b>	<b>440,936.18</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-28,780,205.96</b>	<b>440,936.18</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>C01</b>	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>984,034,175.03</b>	<b>984,034,175.03</b>
<b>C03</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>984,034,175.03</b>	<b>984,034,175.03</b>
C07	Тайлант үеийн үр дүн	6,835,734.08	6,835,734.08
<b>C08</b>	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>946,858,162.73</b>	<b>946,858,162.73</b>
<b>D03</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>946,858,162.73</b>	<b>946,858,162.73</b>
D08	Тайлант үеийн үр дүн	440,936.18	440,936.18
<b>D09</b>	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>947,299,098.91</b>	<b>947,299,098.91</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
		/Төгрөгөөр/	
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>189,823,900.00</b>	<b>157,395,800.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>189,823,900.00</b>	<b>157,395,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>185,079,400.00</b>	<b>142,728,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	185,079,400.00	142,728,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>4,744,500.00</b>	<b>14,667,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	14,667,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,744,500.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>189,823,900.00</b>	<b>157,395,800.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>189,823,900.00</b>	<b>157,395,800.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>151,735,351.29</b>	<b>156,329,464.86</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>94,022,249.64</b>	<b>103,801,911.00</b>
210101	Үндсэн цалин	71,418,245.50	81,725,626.00
210102	Нэмэгдэл	15,387,001.00	11,502,101.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,217,003.14	8,680,700.00
210104	Урамшуулал	00.00	1,893,484.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>12,807,508.87</b>	<b>13,634,699.78</b>
210201	Тэтгэврийн даатгал	8,950,099.90	9,359,706.26
210202	Тэтгэмжийн даатгал	988,288.72	1,101,459.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	760,570.90	846,688.93
210204	Ажилгүйдлийн даатгал	189,224.71	209,122.58
210205	Эрүүл мэндийн даатгал	1,919,324.64	2,117,722.46
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>15,867,699.80</b>	<b>17,220,862.98</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,462,645.03	1,591,920.09
210302	Түлш, халаалт	13,121,756.97	13,381,393.89
210303	Цэвэр, бохир ус	1,283,297.80	2,247,549.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>8,691,699.50</b>	<b>11,902,525.00</b>
210401	Бичиг хэрэг	1,443,997.00	1,161,050.00
210402	Тээвэр, шатахуун	5,419,800.00	8,592,365.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,145,902.50	950,510.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	682,000.00	1,198,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>651,200.00</b>	<b>00.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	651,200.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>808,200.00</b>	<b>1,855,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	178,200.00	855,000.00
210604	Урсгал засвар	630,000.00	00.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,980,600.00</b>	<b>3,148,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,980,600.00	3,148,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>11,645,793.48</b>	<b>2,180,879.10</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,940,993.48	1,684,179.10
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	69,300.00	71,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	51,500.00	95,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	34,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	297,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,260,400.00</b>	<b>2,585,587.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,260,400.00	2,585,587.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>38,088,548.71</b>	<b>1,066,335.14</b>

<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>27,617,400.00</b>	<b>00.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	27,617,400.00	00.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>10,471,148.71</b>	<b>1,066,335.14</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,471,148.71	1,066,335.14
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	/ төгрөгөөр /		
			Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	142,728,800.0	141,662,464.9	1,066,335.1	99.3
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	142,728,800.0	141,662,464.9	1,066,335.1	99.3
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	142,728,800.0	141,662,464.9	1,066,335.1	99.3
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	103,855,700.0	103,801,911.0	53,789.0	99.9
210101	Үндсэн цалин	82,477,800.0	81,725,626.0	752,174.0	99.1
210102	Нэмэгдэл	9,353,300.0	11,502,101.0	-2,148,801.0	123.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,224,600.0	8,680,700.0	-1,456,100.0	120.2
210104	Урамшуулал	4,800,000.0	1,893,484.0	2,906,516.0	39.4
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	14,107,000.0	13,634,699.8	472,300.2	96.7
210201	Тэтгэврийн даатгал	9,592,700.0	9,359,706.3	232,993.7	97.6
210202	Тэтгэмжийн даатгал	1,112,600.0	1,101,459.6	11,140.4	99.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	998,800.0	846,688.9	152,111.1	84.8
210204	Ажилгүйдлийн даатгал	225,800.0	209,122.6	16,677.4	92.6
210205	Эрүүл мэндийн даатгал	2,177,100.0	2,117,722.5	59,377.5	97.3
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	13,174,100.0	13,053,863.0	120,237.0	99.1
210301	Гэрэл, цахилгаан	1,922,800.0	1,591,920.1	330,879.9	82.8
210302	Түлш, халаалт	10,115,500.0	9,716,125.9	399,374.1	96.1
210303	Цэвэр, бохир ус	1,135,800.0	1,745,817.0	-610,017.0	153.7
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,457,600.0	5,273,525.0	184,075.0	96.6
210401	Бичиг хэрэг	913,900.0	1,161,050.0	-247,150.0	127.0
210402	Тээвэр, шатахуун	2,581,500.0	2,613,365.0	-31,865.0	101.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,413,300.0	950,510.0	462,790.0	67.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	548,900.0	548,600.0	300.0	99.9
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,132,600.0	1,132,000.0	600.0	99.9
210702	Дотоод албан томилолт	1,132,600.0	1,132,000.0	600.0	99.9
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,261,700.0	2,180,879.1	80,820.9	96.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,730,000.0	1,684,179.1	45,820.9	97.4
210803	Даатгалын үйлчилгээ	71,200.0	71,200.0	00.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	96,900.0	95,500.0	1,400.0	98.6
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,500.0	33,000.0	33,500.0	49.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	297,100.0	297,000.0	100.0	00.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,740,100.0	2,585,587.0	154,513.0	94.4

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,740,100.0	2,585,587.0	154,513.0	-05.6
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>				
		142,728,800.0	141,662,464.9	1,066,335.1	99.3
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	142,728,800.0	141,662,464.9	1,066,335.1	-00.7
131001	Улсын төсвөөс санхүүжих	142,728,800.0	141,662,464.9	1,066,335.1	-00.7
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>				
		10.00	10.00	00.00	00.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	07.00	07.00	00.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	02.00	02.00	00.00	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>14,667,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>14,667,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>14,667,000.00</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>4,167,000.00</b>
210302	Түлш, халаалт	3,665,268.00
210303	Цэвэр, бохир ус	501,732.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,629,000.00</b>
210402	Тээвэр, шатахуун	5,979,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	650,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,855,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	855,000.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>2,016,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,016,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>14,667,000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>14,667,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,667,000.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>00.00</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

## 3. Аудитын тайлан

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөвсгөл нуур, Эгийн голын сав газрын захиргаа нь гүний болон гадаргын усыг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм. Тайлант онд Сав газарт усны нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, түүнд хяналт тавьж, байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалан, сайжруулах, Хөвсгөл нуур - Хөвсгөл нуур, Эгийн голын цэвэр цэнгэг байдлыг бүрэн хэмжээнд хамгаалах, усны нөөцөд тулгуурласан нийгэм-эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, нийгмийн аюулгүй байдал болон эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах зорилт тавин ажилласан байна.

### 3.2 Байгууллагын гадаад дотоод орчин

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэлээ.

Хөвсгөл нуур, Эгийн голын сав газрын захиргааны даргын 2021 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн А/05 дүгээр тоот тушаалаар дотоод хяналтын зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна. Дотоод хяналтын зөвлөл нь 2022 онд Төлөвлөсөн арга хэмжээний хүрээнд өмчийн болон санхүүгийн бүртгэлийн үйл ажиллагаа, ил тод байдал, мөрдөгдөж буй хууль журмын хэрэгжилт, дотоод үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж, тайлагнасан байна.

Тус байгууллагад тайлант онд хөндлөнгийн хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл нуур, Эгийн голын сав газрын захиргааны 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж Төсвийн тухай хуулийн 54.5 дахь хэсэгт заасны дагуу иж бүрэн тайлагнасан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа бодлогын баримт бичгийг Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2022 оны А/641 тушаалаар баталж мөрдсөн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөвсгөл нуур, Эгийн голын сав газрын захиргааны 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод материаллаг хэмжээний өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 440.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	550.19	00.00	-550.19
Бараа материал	5,299.80	5,299.80	00.0
Биет хөрөнгө	941,008.17	941,999.30	991.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>946,858.16</b>	<b>947,299.10</b>	<b>440.9</b>
Хуримтлагдсан үр дүн	946,858.16	947,299.10	440.9
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>946,858.16</b>	<b>947,299.10</b>	<b>440.9</b>

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, авлага үндсэн хөрөнгө, бараа материал, өр төлбөр гэсэн данс тус бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна. Тайлант онд үндсэн хөрөнгө, бараа материал дансанд дараах хөдөлгөөн хийгдсэн байна. Үүнд:

1. Цэвэр усны төлбөрийн авлагын үлдэгдэл болон тайланд онд үүссэн өр, авлагыг бүрэн барагдуулж, батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.
2. Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас 41,100.0 мянган төгрөгийн автомашин үнэ төлбөргүй авсан байна.
3. 1,000.0 мянган төгрөгийн хангамжийн материал худалдан авсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд 192,510.0 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас урсгал зардлыг 44,038.8 мянган төгрөгөөр бууруулж, 148,471.2 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 148,471.2 мянган төгрөгийн төсөв баталж, 257.6 мянган төгрөгийн хасах тодотгол хийж, 142,728.8 мянган төгрөгийг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлжээ.

Гүйцэтгэлээр 142,728.8 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулж, 1,066.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

#### Хүснэгт 1. Хөтөлбөр, арга хэмжээний зардал

/мянган төгрөгөөр/

Хөтөлбөр, арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>71404</b>	<b>Усны нөөц</b>	<b>142,728.8</b>	<b>141,662.5</b>	<b>1,066.3</b>	<b>99.2</b>
80101	Үндсэн үйл ажиллагаа	140,998.8	139,932.5	1,066.3	99.2
80219	Харуул хамгаалалтын зардал	1,730.0	1,730.0	0.0	100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Байгаль орчин уур амьсгалын сангаас 500.0 мянган төгрөг, Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас 10,000.0 мянган төгрөг, Усны газраас 4,167.0 мянган төгрөг, нийт 14,667.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт хүлээн авч тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл нуур, Эгийн голын сав газрын захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан соёмбо аудит ХХК-ийн захирал Х.Диймаа, аудитор Н.Бадамханд нар гүйцэтгэж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ичинхорлоо, аудитын менежер Б.Тэгшдэлгэр нар анхан шатанд чанарын хяналтыг хэрэгжүүлж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хоёр дахь шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл нуур, Эгийн голын сав газрын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хаан соёмбо аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 14 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

## **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 218,053.9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 4,361.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 буюу 3,488.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зерчилтэй зүйл илрээгүй болно.

## **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд худалдан авах ажиллагааны тайлан болон цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн бүхий 21,486.6 мянган төгрөгийн 2 орлогын гүйлгээг мэдээлээгүй байна. Мөн байгууллагын дарга, нягтлан бодогчийн мэдээллийг шинэчлээгүй байна.

### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Хүн амыг эрүүл аюулгүй ундны усаар хангах нөхцөлийг бүрдүүлэх, усны нөөцийг бохирдохоос урьдчилан сэргийлэх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах зорилгоор тус сав газрын харьяа Хөвсгөл аймгийн Түнэл сум Эгийн голын гүүрнээс Эрдэнэбулган сумын Эг, Үүр голын бэлчир хүртэлх гол доторх болон голын эрэг дагуух хог хаягдал, малын сэг зэмийг цэвэрлэхээр “Цэвэр тунгалаг Эгийн гол” төсөл хэрэгжүүлэн бусад байгууллагын албан хаагчид, иргэдтэй хамтран 740 км замыг туулж, 150 орчим га талбайг хамруулан 106,7 тн хог хаягдлыг цэвэрлэсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байгаа тул зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

## **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Хөвсгөл нуур, Эгийн голын сав газрын захиргааны 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хөвсгөл нуур, Эгийн голын сав газрын захиргааны 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага, зөвлөмж аваагүй байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар онцгойлон үзэх асуудал байхгүй байна.

### 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 21,486.6 мянган төгрөгийн зөрчил илэрч 1 зөвлөмжийг хүргүүлж байна.

#### 5.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

#### 5.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй болно.

#### 5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

##### 1.1. Илрүүлэлт:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд худалдан авах ажиллагааны тайлан болон цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 21,486.6 мянган төгрөгийн 2 орлогын гүйлгээг мэдээлээгүй, байгууллагын дарга, нягтлан бодогчийн мэдээллийг шинэчлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.5 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.2.1, 3.2.10 дахь заалттай тус тус нийцэхгүй байна.

##### 1.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ХАА төлөвлөгөө тайлан, орлогын гүйлгээг дутуу мэдээлсэн	1	21,486.6					1	21,486.6
Нийт дүн	1	21,486.6					1	21,486.6

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР


БАТАЛГААЖУУЛСАН:

АУДИТОР

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Г.ИЧИНХОРЛОО ОГНОО:



Х.ДИЙМАА

Н.БАДАМХАНД

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЗБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

АУДИТОР

Г.ИЧИНХОРЛОО ОГНОО:

БАТАЛГААЖУУЛСАН:

АУДИТОР

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

АУДИТОР



Х.ДИЙМАА

Н.БАДАМХАНД